ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мон-Атом ТӨХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2025/086/НА-СТА-ТӨҮГ**


Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2025 он

**Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор:Ц.Наранчимэг**
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: С.Нацагдорж**
Утас: 260512 Цахим хаяг:Natsagdorjs@audit.gov.mn
**Ахлах аудитор: Б.Эрдэнэзул**
Утас:261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn
**Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Солид Юнити Аудит ХХК-ийн захирал: Э.Мөнхтогтох**
Утас: 99063227 Цахим хаяг:munkhtogtokh.e@solidunity.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1032
танай ____________-ны №____________-т

МОН-АТОМ ТӨХХК-ИЙН ЗАХИРАЛ
Д.ДАЛАЙЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мон-Атом ТӨХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Цөмийн энергийн тухай хуулийн дагуу цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Бадрах Энержи ХХК-ийн 34 хувь, Гурвансайхан ХХК-ийн 15 хувь, Мон-Чех Ураниум ХХК-ийн 51 хувийг эзэмшиж төрийн төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны мөрийн хөтөлбөрт тусгагдсан 14 мега төслийн нэг болох Бүгд Найрамдах Франц Улсын төрийн өмчит Орано групптэй хамтарсан Зөөвч овоо ордыг хамтран ашиглах, уран олборлох “Хөрөнгө оруулалтын төслийн гэрээ”-г 2025 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр үзэглэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус компанийн үндсэн үйлдвэрлэл эхлээгүй, Эрдэнэс Монгол ХХК-тай байгуулсан зээлийн гэрээний дагуу тайлант онд 1,238.6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Компанийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 4 стратеги зорилгын 34 зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 94.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.
Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй

**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0317 SNAG-39.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ХӨРӨНГӨ | | |
| 1.1 | Эргэлтийн хөрөнгө | | |
| 1.1.1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 28,966,814.72 | 45,801,610.58 |
| 1.1.3 | Татвар, НДШ-ийн авлага | 112,164,621.89 | 120,078,587.92 |
| 1.1.4 | Бусад авлага | 1,427,634.06 | 439,789.06 |
| 1.1.6 | Бараа материал | 19,521,577.23 | 14,488,032.33 |
| 1.1.7 | Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 4,400,000.00 | 81,505,530.74 |
| **1.1.11** | **Эргэлтийн хөрөнгийн дүн** | **166,480,647.90** | **262,313,550.63** |
| 1.2 | Эргэлтийн бус хөрөнгө | | |
| 1.2.1 | Үндсэн хөрөнгө | 49,550,837.34 | 54,129,050.21 |
| 1.2.2 | Биет бус хөрөнгө | - | 10,606,060.60 |
| 1.2.4 | Урт хугацаат хөрөнгө оруулалт | 1,716,678,770.00 | 1,716,678,770.00 |
| **1.2.10** | **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | **1,766,229,607.34** | **1,781,413,880.81** |
| **1.3.** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,932,710,255.24** | **2,043,727,431.44** |
| 2 | Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | | |
| 2.1 | ӨР ТӨЛБӨР | | |
| 2.1.1.1 | Дансны өглөг | 4,059,612.67 | 2,565,612.67 |
| 2.1.1.2 | Цалингийн өглөг | 52,480,642.49 | - |
| 2.1.1.3 | Татварын өр | 13,475,570.54 | 17,607,380.57 |
| 2.1.1.4 | НДШ-ийн өглөг | 177,219.00 | 234,818.64 |
| **2.1.1.13** | **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | **70,193,044.70** | **20,407,811.88** |
| 2.1.2 | Урт хугацаат өр төлбөр | | |
| 2.1.2.1 | Урт хугацаат зээл | 10,690,232,732.57 | 12,572,050,729.99 |
| 2.1.2.2 | Нөөц /өр төлбөр/ | - | - |
| **2.1.2.6** | **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | **10,690,232,732.57** | **12,572,050,729.99** |
| **2.2** | **Өр төлбөрийн нийт дүн** | **10,760,425,777.27** | **12,592,458,541.87** |
| 2.3 | Эздийн өмч | | |
| 2.3.1 | Өмч-төрийн | 1,721,206,770.00 | 1,721,206,770.00 |
| 2.3.9 | Тайлант үеийн ашиг (алдагдал) | (1,031,457,320.93) | (1,773,476,230.22) |
| 2.3.10 | Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг (алдагдал) | (9,517,464,971.10) | (10,496,461,650.21) |
| **2.3.1** | **Эздийн өмчийн дүн** | **(8,827,715,522.03)** | **(10,548,731,110.43)** |
| **2.4** | **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **1,932,710,255.24** | **2,043,727,431.44** |

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Борлуулалтын орлого (цэвэр) | 155,070,445.45 | - |
| 2 | Борлуулалтын өртөг | (116,187,909.24) | - |
| 3 | Нийт ашиг | 38,882,536.21 | - |
| 5 | Хүүний орлого | 307,889.09 | 700,508.64 |
| 8 | Бусад орлого | 216,065,250.00 | - |
| 9 | Борлуулалт маркетингийн зардал | - | - |
| 10 | Ерөнхий ба удирдлагын зардал | (627,892,143.08) | (1,007,730,104.02) |
| 11 | Санхүүгийн зардал | (665,607,307.99) | (764,226,235.73) |
| 12 | Бусад зардал | - | (1,780,955.00) |
| 13 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 6,814,444.75 | (369,393.25) |
| 17 | Бусад ашиг (алдагдал) | - | - |
| **18** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(1,031,429,331.02)** | **(1,773,406,179.36)** |
| 19 | Орлогын татварын зардал | (27,989.91) | (70,050.86) |
| **20** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(1,031,457,320.93)** | **(1,773,476,230.22)** |
| 22 | Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал | - | - |
| 23 | Бусад дэлгэрэнгүй орлого | - | |
| 24 | Орлогын нийт дүн | **(1,031,457,320.93)** | **(1,773,476,230.22)** |
| 25 | Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал) | - | - |

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмч | Хуримтлагдсан ашиг (алдагдал) | Нийт Дүн |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл** | **1,675,192,180.00** | **(9,517,464,971.10)** | **(7,842,272,791.10)** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | - | - |
| Залруулсан үлдэгдэл | 1,675,192,180.00 | (9,517,464,971.10) | (7,842,272,791.10) |
| Өмчид гарсан өөрчлөлт | 46,014,590.00 | - | 46,014,590.00 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (1,031,457,320.93) | (1,031,457,320.93) |
| **2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,721,206,770.00** | **(10,548,922,292.03)** | **(8,827,715,522.03)** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга | - | 52,460,641.82 | 52,460,641.82 |
| Залруулсан үлдэгдэл | 1,721,206,770.00 | (10,496,461,650.21) | (8,775,254,880.21) |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | (1,773,476,230.22) | (1,773,476,230.22) |
| **2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,721,206,770.00** | **(12,269,937,880.43)** | **(10,548,731,110.43)** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | 2023 оны 12 дугаар сарын 31 | 2024 оны 12 дугаар сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 1.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 171,124,690.00 | 1,693.83 |
| 1.1.1 | Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 155,070,445.45 | - |
| 1.1.4 | Буцаан авсан албан татвар | 15,507,044.55 | - |
| 1.1.5 | Бусад мөнгөн орлого | 547,200.00 | 1,693.83 |
| 1.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 696,128,372.50 | 942,375,904.82 |
| 1.2.1 | Ажилчдад төлсөн | 290,239,406.10 | 454,384,770.98 |
| 1.2.2 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 93,161,895.90 | 136,239,059.53 |
| 1.2.3 | Бараа материал худалдан авахад төлсөн | 16,097,815.00 | 11,790,430.00 |
| 1.2.4 | Ашиглалтын зардалд төлсөн | - | - |
| 1.2.5 | Хүүний төлбөрт төлсөн | - | 70,050.86 |
| 1.2.6 | Татварын байгууллагад төлсөн | 36,222,505.99 | 48,640,717.97 |
| 1.2.7 | Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| 1.2.8 | Бусад мөнгөн зарлага | 260,406,749.51 | 291,250,875.48 |
| **1** | **Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(525,003,682.50)** | **(942,374,210.99)** |
| 2 | Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 2.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 17,497,295.20 | 14,895,358.64 |
| 2.1.1 | Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | - | |
| 2.1.5 | Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 17,217,396.02 | 14,194,850.00 |
| 2.1.6 | Хүлээн авсан хүүгийн орлого | 279,899.18 | 700,508.64 |
| 2.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 113,055,475.00 | 166,175,033.00 |
| 2.2.1 | Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 10,357,000.00 | 20,167,272.73 |
| 2.2.2 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | - | 13,636,363.63 |
| 2.2.5 | Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 102,698,475.00 | 132,371,396.64 |
| **2** | **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **(95,558,179.80)** | **(151,279,674.36)** |
| 3 | Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ | | |
| 3.1 | Мөнгөн орлогын дүн (+) | 1,152,042,674.92 | 1,117,363,363.00 |
| 3.1.1 | Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 1,152,042,674.92 | 1,117,363,363.00 |
| 3.2 | Мөнгөн зарлагын дүн (-) | 520,060,850.00 | 6,874,681.79 |
| 3.2.1 | Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө | 520,000,000.00 | - |
| 3.2.1 | Бусад мөнгөн зарлага | 60,850.00 | 6,874,681.79 |
| **3** | **Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн** | **631,981,824.92** | **1,110,488,681.21** |
| **4** | **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **11,419,962.62** | **16,834,795.86** |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 17,546,852.10 | 28,966,814.72 |
| **6** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **28,966,814.72** | **45,801,610.58** |

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлтүүд | 2023 оны гүйцэтгэл | 2024 оны зорилт | Өсөлт , бууралт | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| ***Орлого*** | | | | | |
| Борлуулалтын орлого | 155,070,445.5 | - | - | - | - |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 116,187,909.2 | - | - | - | - |
| Цэвэр орлого | 38,882,536.2 | - | - | - | - |
| Хүүгийн орлого | 307,889.1 | - | 700,508.6 | 700,508.6 | 100 |
| Ханшийн зөрүүгийн орлого | 6,814,444.7 | - | - | - | - |
| Бусад орлого | 216,065,250.0 | - | - | - | - |
| ***Нийт орлого*** | **262,070,120.0** | - | **700,508.6** | **700,508.6** | - |
| ***Зардал*** | | | | | |
| Цалингийн зардал | 381,017,641.9 | 573,816,000.0 | 561,361,507.3 | 12,454,492.7 | 97.8 |
| НДШ-ийн зардал | 46,297,460.9 | 77,964,000.0 | 75,962,428.2 | 2,001,571.8 | 97.4 |
| Албан томилолтын зардал | 40,443,789.0 | 214,130,504.0 | 143,351,823.0 | 70,778,681.0 | 66.9 |
| Бичиг хэргийн зардал | 5,739,453.5 | 9,033,200.0 | 8,960,818.2 | 72,381.8 | 99.2 |
| Автомашинтай холбоотой зардал | - | 2,776,750.0 | 1,745,454.5 | 1,031,295.5 | 62.9 |
| Шуудан, харилцаа холбоо, интернэт | 3,489,506.2 | 6,360,000.0 | 3,846,082.3 | 2,513,917.7 | 60.5 |
| Хангамжийн материалын зардал | 6,328,285.8 | 5,471,000.0 | 1,383,635.5 | 4,087,364.5 | 25.3 |
| Сургалт | - | 6,600,000.0 | 1,110,898.3 | 5,489,101.7 | 16.8 |
| Зар сурталчилгааны зардал | 72,790,908.4 | 160,805,456.0 | 72,106,026.9 | 88,699,429.1 | 44.8 |
| Зочин төлөөлөгч хүлээн авалтын зардал | - | 9,600,000.0 | 8,258,616.5 | 1,341,383.5 | 86.0 |
| Түрээсийн зардал | 2,290,200.0 | 6,000,000.0 | 6,495,100.0 | (495,100.0) | 108.3 |
| Нийгмийн арга хэмжээ | 2,284,000.0 | 7,700,000.0 | 7,700,000.0 | - | 100.0 |
| Судалгаа хөгжүүлэлтийн зардал | - | 44,600,000.0 | 43,600,000.0 | 1,000,000.0 | 97.7 |

| Үзүүлэлтүүд | 2023 оны гүйцэтгэл | 2024 оны зорилт | Өсөлт , бууралт | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 54,328,500.0 | 59,700,000.0 | 53,048,749.7 | 6,651,250.3 | 88.9 |
| Санхүүгийн зардал | 665,607,308.0 | 735,158,368.0 | 764,226,235.6 | (29,067,867.6) | 104.0 |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 12,853,051.5 | 34,166,037.0 | 18,619,362.9 | 15,546,674.1 | 54.5 |
| Үйл ажиллагааны бус бусад зардал | 57,335.9 | 2,500,000.0 | 2,400,000.0 | 100,000.0 | 96.0 |
| ***Нийт зардал*** | **1,293,527,441.0** | **1,956,381,315.0** | **1,774,176,738.9** | **182,204,576.1** | **90.7** |
| Татвар төлөхийн өмнөх ашиг, алдагдал | (1,031,457,320.9) | - | (1,773,476,230.2) | - | - |
| Орлогын татварын зардал | 27,989.9 | - | 70,050.9 | - | - |
| Цэвэр ашиг, алдагдал | (1,031,485,310.9) | - | (1,773,546,281.1) | - | - |
| Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал | - | - | - | - | - |
| Нийт авлага | 113,592,256.0 | - | 120,518,377.0 | | - |
| Нийт өглөг | 10,760,425,777.3 | - | 12,592,458,541.9 | - | - |
| Хөрөнгө оруулалтын дүн | - | 51,600,000.0 | 33,803,636.4 | - | - |
| Орон тоо | 10.0 | 10.0 | 10.0 | - | - |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**3.1** Аудитаар нийт 71.9 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 71.9 сая төгрөгийн 5 алдааг залруулсан.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд шинээр ашиглаж эхэлсэн компанийн веб хуудсыг ерөнхий удирдлагын зардлаар бүртгэсэн. | 1 | 13,636.4 | - | - | 1 | 13,636.4 | 1 | 13,636.4 | - | - | - | - |
| Биет бус хөрөнгөөр бүртгэсэн компанийн веб хуудсыг хорогдуулалт тооцоогүй | 1 | 3,030.3 | 1 | 3,030.3 | | | 1 | 3,030.3 | - | - | - | - |
| Оффисын программын зардлыг хангамжийн материалаар бүртгэсэн | 1 | 1,980.0 | - | - | 1 | 1,980.0 | 1 | 1,980.0 | - | - | - | - |
| Оффисын программын тайлант хугацаанд хамаарах зардлыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгээгүй | 1 | 835.4 | 1 | 835.4 | | | 1 | 835.4 | - | - | - | - |
| Компанийн ТУЗ-ийн гишүүн, удирдлагаар ажиллаж байсан нэр бүхий 37 хүнд хамаарах 2014-2016 оны хооронд үүссэн 52.5 сая төгрөгийн цалингийн өглөгийг бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн | 1 | 52,460.6 | - | - | 1 | 52,460.6 | 1 | 52,460.6 | - | - | - | - |
| **Дүн** | **5** | **71,942.7** | **2** | **3,865.7** | **3** | **68,077.0** | **5** | **71,942.7** | **-** | **-** | **-** | **-** |

**3.2** Аудитаар нийт 2.6 сая төгрөгийн 2 санхүүгийн зөрчил[2] илэрснийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг тухайн хөрөнгийн эдийн засгийн нас буюу эдийн засгийн өгөөжид үндэслэн тогтоогоогүй. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Насжилттай өглөгийн үлдэгдлийг баталгаажуулах, болон барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна | 1 | 2,565.6 | - | - | 1 | 2,565.6 | - | - | - | - | - | - |
| **Дүн** | **2** | **2,565.6** | **-** | **-** | **1** | **2,565.6** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

**3.3** АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн зөрчлийг арилгах 2 албан шаардлага хүргүүлэв.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ***Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил*** | | | | | | |
| Компанийн өөрийн хөрөнгөд (төрийн өмчид) гарсан өөрчлөлтийг компанийн дүрэм болон гэрчилгээнд тусгаж хуулийн этгээдийн бүртгэлд бүртгүүлэх гэж өгсөн өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй. | 1 | - | 1 | - | - | - |
| Уран-II баримт кино хийлгэхээр байгуулсан гэрээний хугацаа сунгаж нэмэлт өөрчлөлт оруулаагүй, гэрээний хэрэгжилт хангалтгүй байна. | 1 | 60,000.0 | 1 | 60,000.0 | - | - |
| **Дүн** | **2** | **60,000.0** | **2** | **60,000.0** | **-** | **-** |